

Living the Lotus

4
2021

VOL. 187

Buddhism in Everyday Life

Үүсгэн байгуулагчийн бодрол

“Өөр зүйлс”-тэй учрах

Рисшо Косей Кай байгууллага нь Үүсгэн байгуулагч Нивано Никкёо, хамтран үндэслэгч Наганүма Мёкоо нарын санаачлагаар 1938 онд байгуулагдсан ба “Лянхуан Гурамсан Судар”-ыг гол сургаал номлолоо болгодог, лам бус эгэл хүмүүс нэгдсэн буддын шашны байгууллага юм. Өөрөөр хэлбэл Шагжамүни бурхан багшийн сургаалыг гэр бүл, ажил, нийгмийн амьдралдаа хэрэгжүүлж, дэлхийн энх тайвныг бүтээн байгуулья гэсэн хүсэл зорилготой хүмүүсийн нэгдэл юм. Бид тус байгууллагын ерөнхийлөгч Нивано Ничикоогийн удирдлага дор бурханы сургаалыг түгээх үйлсэд зүтгэж, шашны төдийгүй бусад салбарын байгууллагууд, дэлхийн олон орны хүмүүстэй сэтгэл нэгдэн энх тайвны үйлсэд хувь нэмэр оруулж байна.

Living the Lotus
Vol. 187 (2021.04)

Ахлах редактор: Акагава Кэйичи
Орчуулсан: Ж.Сэлэнгэ, Ж.Гэрэлтуяа
Эхийг хянасан: Монголын РКК
Хэвлэсэн: Рисшо Косей Кай, Олон улсын хэлтэс
Хаяг: Fumon Media Center, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo 166-8537 Japan
TEL: +81-3-5341-1124
FAX: +81-3-5341-1224
Email: living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp


Ажил дээр маш сайн мэддэг хүнтэйгээ хийж дадсан ажлаа хийж байсан нь сэтгэлд амар, үр дүн ч өндөр байх шиг бодогддог. Гэвч тэнд анзаараагүй үлдээсэн цоорхой байдаг.

Тан улсын үеийн Буддизмын Зэн урсгалын багш Нансэны “Танил бус өөр зүйлсийн дундуур туучвал зохилтой.” гэсэн үг байдаг. Өөр зүйл гэдэг нь сударт янз бүрийн хэлбэрээр гарч ирдэг хүнээс бусад амьтан юм. Бид бүхэн үргэлж ижил дасал болсон зүйлсийн дунд байсаар өөрийн зуршил, дуртай, дургүй зүйлс, хайр, үзэн ядалтдаа автаад, хэвшсэн өрөөсгөл өнцгөөсөө салж чаддаггүй. Түүнийг залруулахын тулд зоригтойгоор өөрийн мэдэхгүй ертөнц рүү шинэ учралыг зорин явах нь маш чухал гэсэн утгаар ч энэ үгийг хүлээн авч болно.

Ямар нэг зүйлд дассанаар амарчлах, хялбарчлах хандлагатай болж, зуршил нь ил тод гараад ирдэг талтай. Улмаар өөрийгөө хөгжүүлэхэд саад болж, жижигхэн хэвэнд баригдсан мэт болгож орхидог. Өөрийнхөө дотор унтаж буй боломжийг нээн цэцэглүүлэхэд шинэ учрал хэрэгтэй. Ажил, хичээлийн шинэ жил эхлэх үе бол тэр учралын үе юм. “Өөр зүйлс”-тэй учрах үед сандарч тэвдэж, заримдаа зовж шаналах нь ч бий. Гэвч шинэ учралын цаана гарцаагүй шинэ аз жаргал хүлээж байдаг. Тэгж итгэвэл аз жаргал тань руу эргэх болно.

«Үүсгэн байгуулагчийн үг» 10, Х44-45

Living the Lotus – Buddhism in Everyday Life (Амьд Цагаан Лянхуа судар – Буддизм бидний амьдралд)” хэмээх тус сэтгүүлийн нэрэнд, Цагаан лянхуа судрын сургаалыг өдөр тутмынхаа амьдралд хэрэгжүүлж, шаварт ургадаг үзэсгэлэнт лянхуа цэцэг мэт үр бүтээмжтэй, үнэ цэнэтэй амьдралыг туулцаага гэсэн хүсэл шингэсэн билээ. Бид энэхүү сэтгүүлээр дамжуулан өдөр тутамдаа хэрэгжүүлж болох бурханы сургаалыг дэлхийн өнцөг булан бүрт хүргэж байна.



Ерөнхийлөгчийн айлдвар

Энэ цаг үеийг
хамтдаа туулцгаая

Рисшо Косей Кай, ерөнхийлөгч
Нивано Ничикоо

Сургаалыг хэрэгжүүлснээр бурханы хутаг олдог

Удахгүй 4 сарын 8-нд Шагжамүни бурханы мэндэлсэн өдрийн арга хэмжээ болно. Буддын ном сударт Шагжамүни бурхан төрөнгүүтээ “Тэнгэрийн дээр, доор ганцхан би гайхамшигтай” хэмээн тунхагласан гэдэг. Энэ нь Шагжамүни бурханыг магтсан үлгэр домгуудын нэг ба бурханы шашны жинхэнэ мөн чанарыг үүнээс илүү гайхамшигтайгаар илэрхийлсэн нь үгүй. Энэхүү “Бурхан багшийн мэндэлсэн өдрийн үг”-ийг нэгэн хүн “Зөвхөн би энэ ертөнцөд ховор нандин оршихуй болой.” гэж тайлбарласан байдаг. Зөвхөн Шагжамүни бурхан төдийгүй ямар ч хүн төрсөн цаг мөчөөсөө эхлээд л бусадтай харьцуулашгүй эрхэм оршихуй байдаг гэсэн үг юм. Амь нас хичнээн эрхэм чухал болохыг ухаарч амьдрахыг сургадаг бурханы сургаалын мөн чанарыг ийнхүү Шагжамүни бурханы мэндэлсэн түүхээр дамжуулж өгүүлсэн гэж хэлж болно.

Мөн түүнчлэн бурханы сургаал бол “Хүн хүнээ аврах сургаал” гэдэг. Тэр утгаар нь аваад үзсэн ч дээрх үг нь гүн гүнзгий утгыг агуулдаг.

Шагжамүни бурхан жинхэнэ үнэнийг ухаарч, тэрхүү сургаалын ачаар бид бүхэн аврагдаж, улмаар зовж шаналж буй эргэн тойрныхоо хүмүүсийг аварч буй. Шагжамүни бурханы үеэс үргэлжилсэн энэхүү хүн хүнээ аварч, аврагдах гэсэн буддын шашны түүхээс хүн гэдэг хичнээн гайхамшигтай болохыг харж болно.

Гэхдээ нэг чухал зүйл бол Шагжамүни бурхан “Төрлөө гээд хутагт болдог юм биш. Хийсэн үйлийнхээ үр дүнд хутагт болдог.” гэж айлдсанчлан хүний эрхэм нандин чанар өдөр бүрийн үйлдлийнхээ үрээр өнгөлөгдөн гялалздаг явдал юм. Буддын Зэн урсгалын багш Доогэн “Бурханы үйлийг хэрэгжүүлэх, гэгээрэх хоёр нэгэн бүхэл” гэж айлдсан. Энэ үгээр гэгээрэлд хүрэхийн төлөө бурханы зам мөрийг хэрэгжүүлдэг гэхээсээ илүү зам мөрийг хэрэгжүүлж байна гэдэг нь өөрөө гэгээрсний гэрч гэдгийг илэрхийлсэн. Өөрөөр хэлбэл бурханы сургаалыг өдөр бүр амьдралдаа хэрэгжүүлэх нь бурханы хутаг олохын баталгаа бөгөөд бурханы үйлээр дамжуулж энэрэн нигүүлсэх сэтгэлээ гүнзгийрүүлэх нь бурханы зам мөр ажээ.

Хаврын салхи болон

Цагаан Лянхуа Судрын “Оточийн хаан бодьсадвагийн уг явдлыг өгүүлэх бүлэг”-т бурханы сургаалыг биечлэн хэрэгжүүлэхийн ач холбогдол болон тэрхүү дүр төрх нь олон хүнд “Төгс гэгээрэх сэтгэл”-ийг төрүүлдэг талаар өгүүлдэг. Энэ нь хувийн ашиг сонирхлоо хаян, эхлээд бусдын төлөө хэмээн өөрийгөө зориулж, бие, сэтгэл хийгээд үг хэлээрээ бусдын төлөө үйл хийх аваас өөрөө аз жаргал, баяр хөөртэй болоод зогсохгүй хүмүүсийг ч аз жаргалд хөтлөх гэрэл гэгээ нь болдог гэсэн утгатай.

Үүнийг илүү ойлгомжтойгоор “Бурханы зам мөрд хичээн шамдах гэдэг хүмүүсийн төлөө үйл хийх явдал.” гэж тодорхойлсон хүн ч бий. Шаанти Дэва гэх энэтхэг лам энэрэн нигүүлсэх сэтгэлээ үйлдлээрээ илэрхийлэх нь бурханы зам мөр бөгөөд бурханы шашин гэж хэлсэн байдаг. Тэр тухай буддын ухааны эрдэмтэн Накамүра Хажимэ гуай “Шашны сургаалыг мэддэг байлаа гээд ямар ч утгагүй. Биеэрээ хэрэгжүүлж, ямар нэгэн байдлаар бодитоор илэрхийлж байж үнэ цэнэ нь гардаг.” хэмээн тайлбарлажээ.

Сургаалыг мэддэг байх нь хамаагүй гэсэн үг биш боловч зовлон бэрхшээлтэй тулгарсан хүний хувьд хэн нэгний бодит тусламж юу юунаас илүү чухал байх нь ойлгомжтой.

Тэрхүү халуун дулаан сэтгэлийг хүлээж авах баяр хөөр нь өөрийн хийгээд өрөөл бусдын амь нас хичнээн эрхэм чухал болохыг анзаарч ухаарах боломж болох нь ч байдаг болов уу. Бодитоор хэрэгжүүлсэн ганцхан энэрэнгүй сэтгэлийн үйл хүний сэтгэлийг жинхэнэ үнэнд чиглүүлэх учиг нь болдог. Тийм “Энэрэнгүй сэтгэлийн уран арга” нь чухамдаа Шагжамүни бурханы айлдсан сургаал дэлгэрүүлэх эх үндэс байж болох юм. Корона вирусын цар тахал дэлгэрсэн өнөө цагт энэрэн нигүүлсэх сэтгэл бүр ч үгүйлэгдээд байх шиг.

Энэрэнгүй сэтгэлтэй байхын тулд өөрөө аль болох эгэл даруу амьдрах чухал гэж дээрх Энэтхэг ламтан хэлжээ. Аль болох бага зүйлд сэтгэл ханаж, ямар ч зүйлд талархах гэсэн энгийн амьдралыг мартаж үл болно.

Түүнчлэн “Урин хаврын салхи болоод зовсон нэгний үүдийг тогшихыг хүснэ.” (Сасаки Нобүцуна) гэсэн нэгэн дууны бадаг байдаг. Энэ дуу шиг өнөөгийн нөхцөл байдлыг туулж буй хүмүүсийн зовлон шаналалыг сэтгэлдээ тээн, хаврын сэвшээ салхи мэт энэрэл нигүүлслийн сэтгэлээ илгээх өдөр ирэхийг хүлээе хэмээн бодож байна.

«Косей» 2021 оны 4 дугаар сарын дугаар

Гайхамшигт Ном Лянхуан Гурамсан Сударын бүлэг тус бүрийн тайлбар

Нивано Никкёо

Хутагт Мэлмийгээр Болгоогч бодьсадвагийн хотол үүдийг өгүүлэх 25 дугаар бүлэг

Уг бүлэгт Барагдашгүй Сэтгэлт бодьсадва Шагжамүни бурханаас Хутагт Мэлмийгээр Болгоогч бодьсадваг яагаад ингэж нэрлэсэн талаар асуухад түүний учрыг нарийн тайлбарлаж өгсөн тухай өгүүлдэг.

Гайхамшигт номын ачаар аврагдаж, нигүүлсэхүйн сэтгэлээр аврах

Энэ бүлгийн гол чухал зүйл бол Хутагт Мэлмийгээр Болгоогч бодьсадва нь үргэлж “Авралын объект” мэтээр төсөөлөгдөж ирснийг няцааж, үнэндээ “Жинхэнэ эрдэм оюун”-ы бэлгэ тэмдэг болохыг харуулсан. Жинхэнэ эрдэм оюун гэдэг нь шулуухан хэлэхэд аливаа зүйлийг хоосон ч гэж бодохгүй, түр зуурын зүйл ч гэж бодохгүй аль аль талыг нь харах чадвар буюу дундыг баримталсан жинхэнэ билиг оюун юм. Хүн дээр аваад үзэх юм бол хүний эрх тэгш чанарыг ч, ялгаатай чанарыг ч амилуулж чаддаг, ямар ч хүнд, ямар ч тохиолдолд яв цав тохирдог уян хатан ухаан юм. Цагаан лянхуа судар (Гайхамшигт ном) өөрөө хамаг юмсын жинхэнэ дүр төрхийн талаар айлдсан билиг оюуны судар билээ.

Хутагт Мэлмийгээр Болгоогч бодьсадва бол тэр мэт жинхэнэ эрдэм оюуныг эзэмшигч нэгэн төдийгүй олон хүний зовлон зүдгүүрийг өөр дээрээ авъя гэсэн агуу нигүүлсэхүйн сэтгэлтэй бодьсадва юм.

Бид бүхэн үнэхээр аврагдахын тулд Гайхамшигт номыг ойлгож, түүнийг бясалган, амьдралдаа хэрэгжүүлэхээс өөр арга зам үгүй. Мөн бусдыг үнэхээр аварья гэвэл энэрэн нигүүлсэх сэтгэлийн үүднээс өөрийгөө золиослох хэмжээний үйл хийж, хүмүүсийг судрын сургаалын зам мөр рүү чиглүүлэхээс өөр аргагүй. Энэ талаар Хутагт Мэлмийгээр Болгоогч бодьсадвагийн тухай бодох төдийд долоон зовлонгоос ангижирна гэсэн сургаалаар дамжуулж нарийвчлан айлдсан.

Хэдий тийм ч дээр үеийн хүмүүс тийм хийсвэр зүйлийг судраас барьж авч ойлгох боломжгүй байсан тул Хутагт Мэлмийгээр Болгоогч бодьсадва хэмээх гайхамшигтай нэвт харах хүчтэй, гучин гурван төрлийн төрхөнд хувирч хүссэн газартаа үзэгдэж, агуу нигүүлслийн сэтгэлээр аливаа зовлонгоос аварч хайрладаг, үзэсгэлэнтэй, эелдэг дүр төрхийг гаргаж ирж, түүнд залбирах юм бол сэтгэл зүрх судрын сургаалыг гүн гүнзгий мэдэрч аврагдах болно.” хэмээн айлдсан учиртай.



Хутагт Мэлмийгээр Болгоогч бодьсадва болохсон

Тиймээс орчин үеийн бид Хутагт Мэлмийгээр Болгоогч бодьсадва хэмээх гайхамшигтай хүний дүрийг сэтгэлдээ бодож, “Тийм болох юмсан.” гэсэн хүсэл тэмүүлэлтэй байвал зохилтой. Энэ сэтгэл хэдий хир хүчирхэг байна төдий чинээ ямар ч зовлон бэрхшээл тулгарсан гарцаагүй түүнийг давж гарч чадна. Мөн тийм хүсэл зорилготой байснаар бусдын зовлон шаналлыг хараад өөрийн эрхгүй авралын гараа сунгадаг.



Хотол үүдийг нээх

Энэхүү Хутагт Мэлмийгээр Болгоогч бодьсадва болохсон гэсэн хүсэл нь “Хотол үүдийг нээх” үндэс болдог.

Хотол үүдийг нээхийн “хотол” гэдэг нь өргөнөөр, хаа сайгүй гэсэн утгатай. “Үүд” гэдэг нь мэдээж орох хаалга гэсэн үг ба тэр нь хувираад “Тэр” гэсэн утгыг илэрхийлдэг. Мөн “салбар, хэсэг” зэрэг аливаа юмсыг ангилах үед ч хэрэглэгддэг. Иймээс “Хотол үүд” гэдэг нь “өргөн хүрээнд бүх айл гэрт”, “амьдралын алив асуудал бүхэнд” гэсэн утгыг агуулдаг. Нэгтгээд хэлбэл “Энэ ертөнцийн хаа сайгүй аливаа бүх асуудал, бүх талбарт, эрх чөлөөтэйгөөр орших” гэсэн утгатай.

Өөрөөр хэлбэл “Хотол үүдийг нээх” гэдэг нь Хутагт Мэлмийгээр Болгоогч бодьсадва энэ ертөнцийн газар бүхэнд аливаа асуудал, нөхцөл байдалд тохирсон дүрээр чөлөөтэй гарч ирж, хүмүүсийг авран замчилдаг гэсэн утгыг илэрхийлдэг.

Тэгэхээр Хутагт Мэлмийгээр Болгоогч бодьсадва болох юмсан гэсэн хүсэл нь өрх гэр, нийгэм, улс орон цаашилбал дэлхий дахины хүрээнд тухайн нөхцөл байдал, хүмүүсийн зовлон бэрхшээлд тохирсон аргаар аварна гэсэн хүсэл юм. Энэ нь л чухамдаа Хутагт Мэлмийгээр Болгоогч бодьсадвагийн “Их нигүүлслийн сэтгэлээр зовлонг хүлээн авах” агуу энэрэн нигүүлсэх сэтгэл билээ.





Бусдын зовлонг өөр дээрээ хүлээж авах үйлийг ямар нэгэн байдлаар ямар ч өчүүхэн зүйл байсан хамаагүй нэг ч гэсэн хүн хэрэгжүүлдэг болох юм бол өрх гэр, нийгэм бол мэдээжийн хэрэг, дэлхийн энх тайван ч хий хоосон мөрөөдөл шиг санагдахгүй. Энэ утгаараа “Хотол үүдийг нээх” гэдэг нь уг бүлгийн хамгийн гол сургаал болно.

Цагаан Лянхуа Сударыг хэрэгжүүлснээр ач буян, эрдэм чадварыг хүртдэг

Уг бүлгийн анзааралгүй өнгөрөөж үл болох өөр нэг зүйл гэвэл Хутагт Мэлмийгээр Болгоогч бодьсадвагийн агуу их ач буян хийгээд хүч чадлыг биширсэн Барагдашгүй Сэтгэлт бодьсадва түүнд өөрийн хүзүүний зүүлтийг өгөхөд Хутагт Мэлмийгээр Болгоогч бодьсадва тэр дороо талыг нь Ялж Төгс Нөгчсөн бурханд, талыг нь Олон Эрдэнэт бодьсадвад өргөн барьдаг үйл явдал. Үүгээр Хутагт Мэлмийгээр Болгоогч бодьсадва агуу их ач буяныг хүртэж, эрдэм чадвартай болсон нь Гайхамшигт Ном (Олон Эрдэнэт Бурханы суварга) ба түүнийг айлдан бодигойгоор хэрэгжүүлсэн Шагжамүни бурханы ач буян гэдгийг илэрхийлсэн. Тэгэхээр Хутагт Мэлмийгээр Болгоогч бодьсадвад залбирснаар аз жаргалтай болно гэх зэргээр бодох нь томоохон андуурал гэдэг нь эндээс ойлгомжтой харагдаж байна.





Тарнийн зүйлийг өгүүлэх 26 дугаар бүлэг



Уг бүлэгт Цагаан Лянхуа Судрын өнөөг хүртэлх сургаалд биширсэн хүмүүс “Энэ сургаалыг сахин хамгаалахаа амлаж байна.” хэмээн баттай тангараглаж, сахин хамгаалах бурхан сахиусны тарний талаар өгүүлдэг. Бүлэг тэр чигээрээ Санскрит хэл дээрх тарни (тарни= аливаа муу бүхнийг таслан зогсоож, аливаа сайн сайхан бүхнийг сайшаах хүчтэй нууц үг)-иар бичигдсэн.

Тарнийн ихэнх нь бурхадын жинхэнэ эсвэл өөрөөр дууддаг нэрийг тоочсон байх бөгөөд тухайн бурхадыг дуудаж буй утгатай гэдэг. Өөрөөр хэлбэл бурхадаас хамгаалалдаа багтаахыг хүсэж байна гэсэн үг.

Орчуулах шаардлагагүй таван төрлийн үг хэллэг

Уг бүлэгт хэд хэдэн Санскрит хэлний үгс тэр чигээрээ гардаг. Яагаад Хятад хэл рүү хөрвүүлээгүй вэ хэмээвээс Кумараживагаас эхлээд Буддын судрыг Хятад хэл рүү хөрвүүлсэн хүмүүс яагаад ч хөрвүүлэхгүй байсан нь дээр гэж шийдвэрлэсэн тул эх хэлнийх нь дуудлагатай адил ханзаар оноон зориудаар эх хэлээр нь тэр чигээр нь үлдээсэн. Түүнийг “Орчуулах шаардлагагүй таван төрлийн үг хэллэг” гэнэ.

Нэгдүгээрт, Энэтхэгийн хосгүй онцгой амьтан, ургамал болон үлгэр домогт гардаг нэрс.

Хоёрдугаарт, олон утга агуулгатай үгийг дан ганц үгээр хөрвүүлэхэд үндсэн утга нь хангалттай орчуулагддаггүй үг хэллэг.


Гуравдугаарт, нууцлаг зүйлс. Аливаа нууц үгс бөгөөд хөрвүүлэх юм бол тухайн гүн гүнзгий нууцлаг утга агуулга нь үгүй болдог.

Дөрөвдүгээрт, эртнээс нааш эх хэлээр нь хэрэглэж заншсан зүйлс.

Тавдугаарт, хөрвүүлснээр уг утга нь алдагдах үг хэллэг.

«Лянхуан Гурамсан Сударын бүлэр тус бүрийн тайлбар»,
Нивано Никкёо, Косей хэвлэлийн компани, 1991 он





Олон улсын хэлтсийн даргын булан

Хавар ирлээ

Шагжамүни будда мэндэлсэн энэ сард Нивано ерөнхийлөгч “Бурхан багшийн төрсөн өдрийн шүлэг”-ийг тайлбарлаж, бидний амь нас ямар үнэ цэнэтэй болох, тэр нандин амь насаараа хэрхэн амьдрах нь бурханы зам мөрд нийцэхийг ойлгомжтой айлдсан.

Буддизмын мөн чанарыг ухаарч, Шагжамүни бурхан багшийн сургасан “аврах, аврагдах” зам мөрийн дагуу амьдарч чадах юм бол буддын шашинтан хүний хувьд тэрэн шиг сайхан зүйл үгүй. Бурханы сургаалыг амьдрал ахуйдаа хэрэгжүүлж бурханы зам мөрөөр алхаж байна гэдэг нь бид бурханлаг чанартайн баталгаа гэж ерөнхийлөгч тайлбарлажээ. Би бол ингэж ойлгож, хүлээж авч чадахгүй байсан.

“Сайн сайхан зүйлийг чин сэтгэлээсээ дахин давтан хийх”, “Хэрэгжүүл хэрэгжүүл, бас дахин хэрэгжүүл. Сайхан санагдтал хэрэгжүүл. Өөрийгөө өөрчлөгдтөл хэрэгжүүл. Дараа төрөлдөө ч дахин хэрэгжүүл” хэмээх сургаалууд нь эгэл сүсэгтэн бидэнд зориулсан сургаал. Хэрэгжүүл гэдэг нь мэдээж хэрэг бодьсатвагийн үйлийг хэлж байгаа ба өөрийнхөө болон өрөөл бусдын төлөө энэрэнгүй сэтгэлийн үйлийг хэрэгжүүлэх явдал болно.


Корона вирусыг хүйтэн өвлийн жихүүн салхитай зүйрлэвэл жихүүн салхи зөөлөрч урин хаврын салхи болдог. Дэлхийн хүн төрөлхтөн амар амгалан, баярлаж талархах сэтгэлийг төрүүлэх өдөртэй удахгүй золгоно гэдэгт итгэлтэй байна.

Олон улсын хэлтсийн дарга
Акагава Кэйичи





Rissho Kosei-kai: A Global Buddhist Movement



Rissho Kosei-kai Buddhist Church of Hawaii

2280 Auhuhu Street, Pearl City, HI 96782, USA
TEL: 1-808-455-3212 FAX: 1-808-455-4633
Email: sangha@rkhawaii.org URL: <http://www.rkhawaii.org>

Rissho Kosei-kai Maui Dharma Center

1809 Nani Street, Wailuku, HI 96793, USA
TEL: 1-808-242-6175 FAX: 1-808-244-4625

Rissho Kosei-kai Kona Dharma Center

73-4592 Mamalahoa Highway, Kailua-Kona, HI 96740, USA
TEL: 1-808-325-0015 FAX: 1-808-333-5537

Rissho Kosei-kai Buddhist Center of Los Angeles

2707 East First Street, Los Angeles, CA 90033, USA
POBox 33636, CA 90033, USA
TEL: 1-323-269-4741 FAX: 1-323-269-4567
Email: rk-la@sbcglobal.net URL: <http://www.rkina.org/losangeles.html>

Please contact Rissho Kosei-kai Buddhist Center of Los Angeles

Rissho Kosei-kai Buddhist Center of Arizona

Rissho Kosei-kai Buddhist Center of Colorado

Rissho Kosei-kai Buddhist Center of San Diego

Rissho Kosei-kai Buddhist Center of Las Vegas

Rissho Kosei-kai Buddhist Center of Dallas

Rissho Kosei-kai of San Francisco

1031 Valencia Way, Pacifica, CA 94044, USA
POBox 778, Pacifica, CA 94044, USA
TEL: 1-650-359-6951 Email: info@rkfs.org

Please contact Rissho Kosei-kai of San Francisco

Rissho Kosei-kai of Sacramento

Rissho Kosei-kai of San Jose

Rissho Kosei-kai of New York

320 East 39th Street, New York, NY 10016, USA
TEL: 1-212-867-5677 Email: rkny39@gmail.com URL: <http://rk-ny.org>

Rissho Kosei-kai of Chicago

1 West Euclid Ave., Mt. Prospect, IL 60056, USA
TEL: 1-773-842-5654
Email: murakami4838@aol.com URL: <http://rkchi.org>

Rissho Kosei-kai of Fort Myers

URL: <http://www.rkftmyersbuddhism.org>

Rissho Kosei-kai Dharma Center of Oklahoma

2745 N.W. 40th St., Oklahoma City, OK 73112, USA
POBox 57138, Oklahoma City, OK 73157, USA
TEL: 1-405-943-5030 FAX: 1-405-943-5303
Email: rkokdc@gmail.com URL: <http://www.rkok-dharmacenter.org>

Rissho Kosei-kai Dharma Center of Denver

1255 Galapago St. #809 Denver, CO 80204, USA
TEL: 1-303-446-0792

Rissho Kosei-kai Dharma Center of Dayton

617 Kling Drive, Dayton, OH 45419, USA
URL: <http://www.rkina-dayton.com>

The Buddhist Center Rissho Kosei-kai International of North America (RKINA)

2707 East First St., Suite #1, Los Angeles, CA 90033, USA
TEL: 1-323-262-4430 FAX: 1-323-269-4567
Email: dharmasa@rksabuddhistcenter.org
URL: <http://rksabuddhistcenter.org>

Rissho Kosei-kai Buddhist Center of San Antonio

(Address) 6083 Babcock Road, San Antonio, TX 78240, USA
(Mail) POBox 692148, San Antonio, TX 78249, USA
TEL: 1-210-558-4430 FAX: 1-210-696-7745
Email: dharmasanantonio@gmail.com
URL: <http://www.rkina.org/sanantonio.html>

Rissho Kosei-kai of Seattle's Buddhist Learning Center

28621 Pacific Highway South, Federal Way, WA 98003, USA
TEL: 1-253-945-0024 Email: rkseattlewashington@gmail.com
URL: <http://buddhistlearningcenter.org>

Rissho Kosei-kai of Vancouver

Please contact RKINA

Rissho Kosei-kai do Brasil

Rua Dr. José Estefno 40, Vila Mariana, São Paulo-SP, CEP 04116-060, Brasil
TEL: 55-11-5549-4446, 55-11-5573-8377
Email: risho@rkk.org.br URL: <http://www.rkk.org.br>

Risho Kosei-kai de Mogi das Cruzes

Av. Ipiranga 1575-Ap 1, Mogi das Cruzes-SP, CEP 08730-000, Brasil

在家佛教韓國立正佼成會

〒 04420 大韓民國 SEOUL 特別市龍山區漢南大路 8 路 6-3
6-3, 8 gil Hannamdaero Yongsan gu, Seoul, 04420, Republic of Korea
TEL: 82-2-796-5571 FAX: 82-2-796-1696

在家佛教韓國立正佼成會釜山支部

〒 48460 大韓民國釜山廣域市南區水營路 174, 3F
3F, 174 Suyoung ro, Nam gu, Busan, 48460, Republic of Korea
TEL: 82-51-643-5571 FAX: 82-51-643-5572

社團法人在家佛教立正佼成會

台灣台北市中正區衡陽路 10 號富群資訊大廈 4 樓
4F, No. 10, Hengyang Road, Jhongheng District, Taipei City 100, Taiwan
TEL: 886-2-2381-1632, 886-2-2381-1633 FAX: 886-2-2331-3433

台南市在家佛教立正佼成會

台灣台南市崇明 23 街 45 號
No. 45, Chongming 23rd Street, East District, Tainan City 701, Taiwan
TEL: 886-6-289-1478 FAX: 886-6-289-1488
Email: koseikaitainan@gmail.com

Rissho Kosei-kai South Asia Division

Thai Rissho Friendship Foundation
201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkok, Huaykhwang, Bangkok 10310, Thailand
TEL: 66-2-716-8141 FAX: 66-2-716-8218

Rissho Kosei-kai of Kathmandu

Ward No. 3, Jhamsikhel, Sanepa-1, Lalitpur, Kathmandu, Nepal

Rissho Kosei-kai of Kolkata

E-243 B. P. Township, P. O. Panchasayar, Kolkata 700094, India

Rissho Kosei-kai of Kolkata North

AE/D/12 Arjunpur East, Teghoria, Kolkata 700059,
West Bengal, India

Rissho Kosei-kai of Bodhgaya Dharma Center

Ambedkar Nagar, West Police Line Road, Rumpur, Gaya-823001,
Bihar, India

Rissho Kosei-kai of Patna Dharma Center

Please contact Rissho Kosei-kai of Kolkata

Rissho Kosei-kai of Central Delhi

77 Basement D.D.A. Site No. 1, New Rajinder Nagar,
New Delhi 110060, India

Rissho Kosei-kai of Singapore

Please contact Rissho Kosei-kai International

Rissho Kosei-kai of Phnom Penh

W.C. 73, Toul Sampaov Village, Sangkat Toul Sangke, Khan Reouseykeo,
Phnom Penh, Cambodia

RKISA Rissho Kosei-kai International of South Asia

Thai Rissho Friendship Foundation
201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkok, Huaykhwang, Bangkok 10310, Thailand
TEL: 66-2-716-8141 FAX: 66-2-716-8218

Rissho Kosei-kai of Bangkok

Thai Rissho Friendship Foundation
201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkok, Huaykhwang, Bangkok 10310, Thailand
TEL: 66-2-716-8216 FAX: 66-2-716-8218 Email: info.thairissho@gmail.com

Rissho Kosei Dhamma Foundation

No. 628-A, Station Road, Hunupitiya, Wattala, Sri Lanka
TEL: 94-11-2982406 FAX: 94-11-2982405

Rissho Kosei-kai of Polonnaruwa

Please contact Rissho Kosei Dhamma Foundation

Rissho Kosei-kai Bangladesh

85/A Chanmari Road, Lalkhan Bazar, Chittagong, Bangladesh
TEL: 880-2-41360470

Rissho Kosei-kai Mayani

Mayani Barua Para, Mirsarai, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai Damdama

Damdama Barua Para, Mirsarai, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai Satbaria

Village: Satbaria Bepari Para, Chandanaih, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai Chendhirpuni

Village: Chendhirpuni, P.O.: Adhunogar, P.S.: Lohagara, Chittagong,
Bangladesh

Rissho Kosei-kai Raozan

Dakshin Para, Ramzan Ali Hat, Raozan, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai Laksham

Village: Dhupchor, Laksham, Comilla, Bangladesh

Rissho Kosei-kai Dhaka

408/8 DOSH, Road No 7 (West), Baridhara, Dhaka, Bangladesh

Rissho Kosei-kai Cox's Bazar

Ume Burmize Market, Tekpara, Sadar, Cox's Bazar, Bangladesh

Please contact Rissho Kosei-kai Bangladesh

Rissho Kosei-kai Patiya**Rissho Kosei-kai Ramu****Rissho Kosei-kai Aburkhiln****Buddiyskiy khram "Lotos"**

4 Gruzinski Alley, Yuzhno-Sakhalinsk 693005, Russia
TEL: 7-4242-77-05-14

Rissho Kosei-kai of Hong Kong

Flat D, 5/F, Kiu Hing Mansion, 14 King's Road, North Point, Hong Kong, China

Rissho Kosei-kai Friends in Shanghai**Rissho Kosei-kai of Ulaanbaatar**

(Address) 15F Express Tower, Peace avenue, khoro-1, Chingeltei district,
Ulaanbaatar 15160, Mongolia
(Mail) POBox 1364, Ulaanbaatar-15160, Mongolia
TEL: 976-70006960 Email: rkkmongolia@yahoo.co.jp

Rissho Kosei-kai of Erdenet

Please contact Rissho Kosei-kai International

Rissho Kosei-kai di Roma

Via Torino, 29, 00184 Roma, Italia
TEL/FAX: 39-06-48913949 Email: roma@rk-euro.org

Please contact Rissho Kosei-kai di Rome

Rissho Kosei-kai of Paris**Rissho Kosei-kai of Venezia****Rissho Kosei-kai of the UK**

29 Ashbourne Road, London W5 3ED, UK
TEL: 44-20-8933-3247 Email: info@rkuk.org URL: <https://www.rkuk.org>
Facebook: <https://www.facebook.com/rkuk.official>
Twitter: https://twitter.com/rkuk_official
Instagram: https://www.instagram.com/rkuk_official

Rissho Kosei-kai International Buddhist Congregation (IBC)

166-8537 東京都杉並区和田 2-7-1 普門メディアセンター 3F
Fumon Media Center 3F, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo 166-8537, Japan
TEL: 03-5341-1230 FAX: 03-5341-1224 URL: <http://www.ibt-rk.org>